



**ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН**

1

**Аудитын код: АРА-
2017/17/СТА-ТШЗ**

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70333141
Цахим хаяг:

Аудитын менежер:
Утас: 70332860
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Архангай
аймгийн Аудитын газар
Байршил: Эрдэнэбулган сум
Цахим хуудас:
www.audit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Менежмент захидал

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	3
2.1	Оршил	3
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	3
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Орлого.....	12
3.2	Өглөг.....	13

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
АРХАНГАЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: (976) 7033-3141
E-mail: arkhangai@audit.gov.mn

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Ж.ГУРВАНТАМИР
ТАНАА

2017.03.23 № 100.
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Архангай аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэбулган сумын ТЭЗ-ын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Эрдэнэбулган сумын ТЕЗахирагч Ж.Гурвантамир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Эрдэнэбулган сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрдэнэбулган сумын Засаг даргын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.03.05-наас 2017.03.25-ны хооронд хийж, аудитын тайланг эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн Аудитор П.Энхжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэбулган сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа төрийн аудитын байгууллагад 2017.03.06-ны өдрийн 26-р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж– Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрдэнэбулган сумын Засаг дарга “Монгол улсын ЗЗНДТУТХуулийн 18.1 дэх хэсэгт “Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд өөрийн эрхлэх хүрээний асуудлыг онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.Үүнд:

Эрдэнэбулган сумын Засаг дарга дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Эрдэнэбулган сумын Засаг дарга “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэд хүнд сурталгүй аливаа чирэгдэлгүй, хурдан шуурхай үйлчлэх явдлыг хэвшүүлж, эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй нягт уялдсан цэгцтэй, уян хатан бөгөөд үр ашигтай үйлчилгээг бий болгоно.” гэсэн зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Эрдэнэбулган сумын Засаг даргын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар баталсан Төсвийн орлогын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангилал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгын маягт”-ыг 2 дугаар хавсралтыг 341 дүгээр тушаалаар батлан тус бүр мөрдөн ашиглаж байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь

материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрдэнэбулган сумын Засаг даргын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Эрдэнэбулган сумын Засаг дарга санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Plastic” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Эрдэнэбулган сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 20 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд, 16 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 12 буюу “бага” байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Материаллаг байдлын түвшинг 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 31.9 сая төгрөгөөр буюу санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын 1 хувиар тооцсон дүнг сонгон авлаа.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь тухайн байгууллагын тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 6 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 50 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	2	10.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	10.5	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар сумын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн талаар дараахь зөрчил илэрлээб

- Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 08 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 467.4 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 590.6 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 126.4%-иар биелэсэн хэдий ч 4 нэр төрлөөр 0.6-2.9 сая төгрөгөөр тасарсан, 7 нэр

төрлөөр 0.5-57.6 сая төгрөгөөр давсан байгаа нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь: Эрдэнэбулган сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангуулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

- Мөн Сум хөгжүүлэх сангийн орлогыг **200.0** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр **143.8** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө **71.9** хувьтай байгаа бөгөөд орлогын төлөвлөгөөг **56.2** сая төгрөгөөр тасалсан байна.

Шийдвэрлэсэн нь: Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд онцгой анхаарч холбогдох арга хэмжээг авч, орлогын төлөвлөгөөг оновчтой төлөвлөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

- Эрдэнэбулган сумын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 3.1 сая төгрөгийн өр төлбөртэй байгаагийн 2.8 сая төгрөг нь Хоршоололын хүүхдийн цэцэрлэг, 0.3 сая төгрөг нь Хоршоололын эрүүл мэндийн төвийн өр байна. Төсвийн байгууллагууд өр төлбөртэй байгаа нь “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрдэнэбулган сумын Засаг дарга өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1297578200 төгрөг, хөрөнгийн зардалд 209284700 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/сая төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1704.7	1565.8	91.8%	138.9
1.1	Урсгал зардал	1297.6	1294.4	99.8%	3.1

1.2	Хөрөнгийн зардал	209.3	134.0	64.0%	75.3
	Эргэж төлөгдөх				
1.3	төлбөрийг хассан	197.9	137.4	69.4%	60.5
	цэвэр зээл				

Тайлант оны төсвийн гүйцэтгэл 91.8 хувьтай байна. Төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү **138.9** сая төгрөг байна. Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл **75.3** сая төгрөг, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөгдөх зээлийн төлөвлөгөө гүйцэтгэлийн зөрүү **60.5** сая төгрөг, төсөвт байгууллагуудын төвлөрүүлэх шилжүүлэг **0.3** сая төгрөг, дутуу санхүүжигдсэн **2.8** сая төгрөгөөр тус тус зөрүүтэй харагдаж байна.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016.12.19-ны өдрийн 08 тоот тогтоолоор сум хөгжүүлэх сангийн орлогыг **200.0** сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр **143.8** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 71.9 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө **467.4** сая төгрөгөөр батлагдаж **590.6** сая төгрөгийн буюу орлого 126.4 %ийн гүйцэтгэлтэй байна. Төсвийн орлого 7 нэр төрөл дээр **131.1** сая төгрөгөөр давж биелсэн бол 4 нэр төрлийн орлого **7.4** сая төгрөгөөр тасарч төлөвлөгөө нийт дүнгээрээ **123.7** сая төгрөгөөр давсан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт **6.8** сая төгрөг зарцуулагдсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэбулган сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн 06 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөөг 270.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 294.0 сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө 108.8%-иар биелэсэн хэдий ч 4 нэр төрлөөр 0.1-12.7 сая төгрөгөөр тасарсан байсанд аудитаас:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох гэсэн зөвлөмж хүргүүлсэн боловч биелүүлж ажиллаагүй байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэбулган сумын Засаг даргын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэбулган сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрдэнэбулган сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв.

3.1 Орлого

Илрүүлэлт

- ✚ Эрдэнэбулган сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 08 тоот тогтоолоор төсвийн орлогын төлөвлөгөө 467.4 сая төгрөгөөр батлаж 590.6 сая төгрөгөөр төвлөрч орлогын төлөвлөгөө 126.4%-иар биелэсэн хэдий ч 4-н нэр төрлийн орлого нийт 0.6-2.9 сая төгрөгөөр тасарсан, 7 нэр төрлөөр 0.5-57.6 сая төгрөгөөр давсан байгаа нь орлогын төлөвлөлт оновчгүй, шахуу төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.
- ✚ Мөн Сум хөгжүүлэх сангийн орлогыг **200.0** сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр **143.8** сая төгрөг төвлөрч орлогын төлөвлөгөө **71.9** хувьтай байгаа бөгөөд орлогын төлөвлөгөөг **56.2** сая төгрөгөөр тасалсан байна.

Зөвлөмж

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг орлогын нэр төрлөөр жигд хангуулж ажиллах
- Орлого тасарч, давж байгаа шалтгааныг орлогын нэр төрөл бүр дээр судлан, төлөвлөлтийг оновчтой болгох
- Төсвийн тухай хуулийн 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах
- Сум хөгжүүлэх сангаас иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтөнд онцгой анхаарч холбогдох арга хэмжээг авч ажиллах

Хариуцах ажилтан

Аудитор.....П.Энхжаргал

Эрсдэл

- Сумын ИТХ-аар баталсан Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө орлогын нэр төрлөөр биелэгдээгүйгээс санхүүжилтийн эх үүсвэр дутагдах эрсдэлтэй байх
- Орон нутгийн Төсвийн Төвлөрүүлэн захирагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг биелэгдэхгүй байх

Төсвийн захирагчийн хариу

3.2 Өглөг

Илрүүлэлт

Эрдэнэбулган сумын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 3.1 сая төгрөгийн өр төлбөртэй байгаагийн 2.8 сая төгрөг нь Хоршоололын хүүхдийн цэцэрлэг, 0.3 сая төгрөг нь Хоршоололын эрүүл мэндийн төвийн өр байна.

Төсвийн байгууллагууд өр төлбөртэй байгаа нь “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байх.

Зөвлөмж

- Өр төлбөрийг барагдуулахад тодорхой арга хэмжээ авч холбогдох байгууллагад санал хүргүүлэн шийдвэрлүүлэх.
- Цаашид Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Хариуцах ажилтан

Аудитор.....П.Энхжаргал

Эрсдэл

- Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх
- Төсвийн хөрөнгийн үр ашиг буурах

Төсвийн захирагчийн хариу

